



ОРХОН АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРООНД

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024. 07. 31. № 217

танай _____ -ны № _____ -т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Орхон аймгийн Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 – 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 – 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн


2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Орхон аймгийн Ардчилсан намын Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

6
Намын мөрийн хөтөлбөр хуудсыг хавсаргав.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ





Орхон аймгийн Ардчилсан намын хорооны
2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн ээлжит
11...Р.хуралдааны 6... дугаар тогтолцоогоо хавсралт

9023041590
8458916 XTO7564

ОРХОН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Монгол Улсын тусгаар тогтолцол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх чөлөө, шудрага хуулийн засаглал, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн намын хувьд,

Хүн бүр ажил, хөдөлмөр эрхлэн, боловсролтой, орлоготой, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээ хүртээмжтэй, хүрээлэн буй орчноо хөгжүүлсэн аймаг болохын төлөө 2024 оны Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд “Эрчимт хөгжлийн төлөө” мөрийн хөтөлбөрийг толилуулж байна.

НЭГ. ИРГЭД

1. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид

- Төрийн оролцоотой хийгдэж байгаа гэр хорооллын гэрэлтүүлгийн үйлчилгээ, нийтийн тээврийн үйлчилгээ, хог хаягдлын үйлчилгээнд менежментийн шинэчлэл хийж, хувийн хэвшлийн оролцоотой хамтран гүйцэтгэнэ.
- Гарааны, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан хөрөнгө оруулалт, зээл олгох мэдээллийг нээлттэй байлгаж, шударгаар олгох механизмыг бүрдүүлнэ.

2. Малчид, тариаланчид

- Мал, малын гаралтай бүх төрлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрийг дэмжин, бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлж, эдийн засгийн эргэлтийг хурдаасгах замаар малчдын амьжиргаа, орлогыг дээшлүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.
- Тариалан эрхлэгчид, хүнсний ногоо тариалагчдыг бодлогоор дэмжинэ.
- Газар тариалангийн бүс нутагт услалтын системийн менежментийг боловсронгуй болгож, тариалан эрхлэгч, хүнсний ногоо тариалагчдыг бодлогоор дэмжинэ.

3. Төрийн албан хаагчид

- Төрийн албан хаагчдыг илүү цагаар ажиллуулахаар бол хуульд заасан хэм хэмжээний дагуу зохих нэмэгдэл хөлсийг олгодог тогтолцоог хэвшүүлнэ.
- Төрийн албан хаагчдыг ажлын ур чадвараа ахиулах, сурч боловсрохыг дэмжих оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.

4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

- Тусгай хэрэгцээт иргэдтэй ажиллах мэргэжилтэн, дохионы хэлний орчуулагч, багшийг бэлтгэх арга хэмжээ авна.
- Төрийн байгууллагуудад дохионы хэлмэрч орон тооны бус хэлбэрээр ажиллуулна.

- Сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан орчин үеийн программчилсан технологийг ашиглуулах нөхцлийг бүрдүүлнэ.

- Тусгай хэрэгцээт иргэд саадгүй нэвтрэх, гарах боломжтой байдлаар төлөвлөлт, стандартыг хянан бүртгэж, алдааг залруулах ажлыг цогцоор үе шаттай хэрэгжүүлнэ.

5. Хүүхдүүд

- Хүүхдийн паркыг орчин үеийн, олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэнэ.
- ЕБС-ийн сурагчдад зориулсан дотуур байрны төсөл хэрэгжүүлнэ.
- Хүүхдийн зуны зусланг нэмэгдүүлнэ.

6. Залуучууд

- Амралт, чөлөөт цагийг боловсон өнгөрүүлэх залуусын цогцолбор төвийг байгуулна.
- Англи хэлийг сурх, сургах эрчимт хөтөлбөрийг хэрэгжүүлэх өмчийн бүх хэлбэрийг дэмжин ажиллана.

- Олон улсын стандартын шаардлагад нийцсэн сагсан бөмбөг, гар бөмбөг, хөнгөн атлетик зэрэг спортын ордон байгуулах төсөл хэрэгжүүлнэ.

7. Ахмадууд

- Асрах хүнгүй ахмадад зориулсан өдөр өнжүүлэх, тэдний нийгмийн оролцооны дэмжлэгийн төвийг бий болгоно.
- Ахмадын эмчилгээ, сувилгааны төвийг өмчийн бүх хэлбэрээр дэмжин ажиллана.

8. Эмэгтэйчүүд

- Хүүхэд харах үйлчилгээг үргэлжлүүлэн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

ХОЁР. БОЛОВСРОЛ

- 2.1 Сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэн, бага насны хүүхдийг нэг км радиус дотор сургуульд хамрагдах боломжийг бүрдүүлнэ.
- 2.2 Бага ангийн нэг ангийн хүүхдийн тоог 35-аас хэтрүүлэхгүйг баримтлана.
- 2.3 Сургуулийн автобусны хүртээмжийг нэмэгдүүлэн, хүүхдийг сургуульдаа аюулгүй ирж, буцах үйлчилгээг хувийн хэвшлийн оролцоотой хэрэгжүүлнэ.
- 2.4 Цэцэрлэгийн ажиллах цагийн хувиарыг уян хатан зохион байгуулж, уртгасан, зуны, тусгай хэрэгцээт, гэр гэх мэт хувилбаруудыг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлж, эцэг, эхчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.
- 2.5 Цэцэрлэгийн болон ЕБС-ийн үдийн хоолны стандартыг шинэчилж, орц найрлагыг нэмэгдүүлж, шим тэжээл, амин дэмээр баялаг хоол, сүү сүүн бүтээгдэхүүнээр үйлчилэх нөхцлийг бүрдүүлнэ.
- 2.6 Техникийн болон инженерийн чиглэлээр төрөлжсөн ЕБС-ийг байгуулна.
- 2.7 Тусгай хэрэгцээт хүүхдийн тасралтгүй боловсрол эзэмших боломж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.8 Мэргэжлийн сургалт үйдвэрлэлийн төвүүдэд орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд нийцсэн мэргэжлийн шинэ анги нээж, сургалтын хөтөлбөрийг шинэчилнэ.
- 2.9 Дэлхийн шилдэг их, дээд сургуульд суралцах оюутны идэвхи, санаачилгыг дэмжинэ.
- 2.10 Хүүхдэд тулгарч буй дээрэлхлэлт, үе тэнгийнхэний дарамт, шахалт болон эрүүл мэнд, сэтгэцийн бусад сорилт, бэрхшээлтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

- 2.11 Хүүхдийг цахим дарамт, мөлжлөг, зохисгүй контент зэрэг цахим гэмт хэрэг, учирч болох аюулаас урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.12 Хүүхдийн болон гэр бүлийн хүчирхийллийн эсрэг, нийгмийн эгэх хариуцлага, тэгш хүртээмжийн талаар үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудад бодлогын дэмжлэг үзүүлж, хамтран ажилана.
- 2.13 Иргэн бүрийн насан туршдаа суралцахуйн хэрэгцээ, шаардлагыг дэмжинэ.
- 2.14 ЕБС-ийн сурагчдад зориулсан “Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм” судлах онлайн хөтөлбөр хичээлийг боловсруулж, сурагчдыг хамруулна.

ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНД

- 3.1 Эрүүл мэндийн байгууллагын хүртээмжийг стандартын шаардлагад нийцүүлэн сайжруулж, эмнэлэгийн төрөл, үйлчилгээг нэмэгдүүлнэ.
- 3.2 Иргэдийг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, эмчлэх чиглэлээр үр дүнтэй ажлуудыг дэмжиж, хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.3 Бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, эмчлэх чиглэлээр үр дүнтэй ажлуудыг дэмжиж, хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.4 Өрхийн эмнэлэгийн дэргэд мэргэжлийн хоол зүйчийг бэлтгэж, хүн амд үйлчилгээ үзүүлнэ.
- 3.5 Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хүртээмж, орчныг сайжруулна.
- 3.6 Эмч, эмнэлэгийн ажилчдын ур чадварыг дээшлүүлэх, тасралтгүй сурч хөгжих бололцоогоор хангаж, дэмжинэ.
- 3.7 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор нисдэг тэргээр үйлчилгээ үзүүлэх боломжийг нээнэ.
- 3.8 Сэргээн засах, хөнгөвчлөх эмчилгээ болон парамедикийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, туслах сувилагчийг бэлтгэнэ.
- 3.9 Бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, эрүүл аж төрөх дадлыг хэвшүүлнэ.

ДӨРӨВ. ХОТЖИЛТ, ДЭД БҮТЭЦ, ГАЗРЫН ХАРИЛЦАА

- 4.1 Хотын ерөнхий төлөвлөгөөг 2045 он хүртэл боловсруулж, батлуулах ажлыг яаралтай зохион байгуулна.
- 4.2 Хотын ерөнхий архитектуроор мэргэшлийн зэрэгтэй архитектур, хот төлөвлөлтийн мэргэжилтэн байхаар сонгон шалгаруулж ажиллуулна.
- 4.3 Эрдэнэт хотын удирдлагын шийдвэр гаргалтанд мэргэжлийн холбоод, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд, иргэдийн сонирхлын бүлгүүдийн оролцоог хангана.
- 4.4 Дугуйн болон явган хүний замыг орчин үеийн стандартад нийцүүлэн шинээр барьж байгуулна.
- 4.5 Хот төлөвлөлтийг ил тод, нээлттэй болгож, олон нийтийн хяналттай хэрэгжүүлнэ.

- 4.6 Иргэн, аж ахуйн нэгж сэргээгдэх эрчим хүчийг жижиг, дунд төхөөрөмжөөр үйлдвэрлэж хэрэглэх, хэрэгцээнээс давсан хэсгийг нэгдсэн сүлжээнд нийлүүлэх, худалдах боломжоор хангана.
- 4.7 Хотын хөгжилд оруулах иргэдийн санал, хүсэлт, санаачлагыг бүртгэх, хүлээн авах, бодлогод тусгах нэгдсэн платформ бий болгоно.
- 4.8 Нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулан хувийн хэвшлийн оролцоог дэмжинэ.
- 4.9 Хөрш аймгуудтай болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “зуслангийн төсөл”-ийг дэмжиж, хамтран ажиллана.
- 4.10 Хөрш аймаг, сумдтай хамтран ажиллах, шинэ суурьшлын бүс, нийгмийн дэд бүтцийн ашиглалт хүртээмжийг нэгдсэн төлөвлөлт гарган хэрэгжүүлнэ.
- 4.11 Гудамжийг иргэд, аж ахуйн нэгжүүдийн оролцоотой тохижуулах, хөрөнгө оруулалт хийж, өөрсдийн нэрээр нэрлэх боломжийг бүрдүүлнэ.
- 4.12 1 цагийн ачааллаас хамааран авто замын шинэчлэл, бүтээн байгуулалтыг эрэмблэнэ.
- 4.13 Гамшгийн үед ашиглах орц, гарц, замыг чөлөөлж, явган зорчигчийн зам, талбайг орхигдуулсан, хаасан иргэн, хуулийн этгээдэд оногдуулах хариуцлагыг өндөржүүлнэ.
- 4.14 Эрдэнэт хотын хүнсний аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр стандартуудыг мөрдөж, хүнсэн дэх хорт бодисыг хэмждэг лаборатори байгуулна.
- 4.15 Авто зогсоолын тоог дорвитой нэмэгдүүлнэ.
- 4.16 Орон сууцны хорооллын явган хүний гарц, орц болон машины хурд сааруулагчийг стандартын дагуу нэмэгдүүлнэ.
- 4.17 Хотын төв замын ачааллыг бууруулах чиглэлээр Булган-Мөрөнгийн замыг шинээр төлөвлөж /хуучин тээврийн товчоо/ аялал, жуулчлалын зам зуурын зочид буудал, хоолны газрын шинэ төвлөрөл бүхий суурьшлыг бий болгон, хотын нэг захаас нөгөөд очих хурдыг нэмэгдүүлнэ.
- 4.18 Автомашины замын уулзваруудын нэвтрэх чадварыг сайжруулан, гэрэл дохиог стандартын дагуу шинэчилнэ.

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН

- 5.1 Хотын бүсэд харшил үүсгэгч шарилж, зэрлэг ургамлыг устгаж, иргэдийн эрүүл таатай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.
- 5.2 Хог хаягдлын менежментийн шат дараалсан системтэй үйл ажиллагаа явуулна.
- 5.3 Ногоон хөгжлийг дэмжин мод тарих, ойн сан хамгаалах, усан сан, парк байгуулах, ойн төгөл, цэцэрлэгт хүрээлэн байгуулах иргэдийн бүлэг, нөхөрлөл, ААН-ийн санал санаачлагыг дэмжинэ.
- 5.4 Агаарын чанарыг дээшлүүлэх болон хөрсний бохирдлыг багасгахад иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшилтэй хамтран ажиллана.
- 5.5 Шахмал түлшийг нүүрснээс өөр бодисоор бий болгоход хувийн хэвшлийг дэмжин хамтран ажиллана.
- 5.6 Сэргээгдэх эрчим хүч, байгаль орчинд ээлтэй дэд бүтцийн шийдлүүдийг хөнгөлөлттэй санхүүжилтээр дэмжинэ.
- 5.7 Эрдэнэт голыг сэргээх, хамгаалах, арчлах зорилгоор голын эрэг дагасан ногоон бүс, ойжуулалт хийнэ.
- 5.8 Усалгаанд зориулсан хиймэл цөөрөм байгуулна.

ЗУРГАА. ГЭР ХОРООЛЛЫН ХӨГЖИЛ

- 6.1 Гэр хорооллын инженерийн шугам сүлжээний мэдээлэл, үйлчилгээний төв байгуулна.
- 6.2 Хог таталтыг хувийн хэвшлийн оролцоотой хамтран шинэ тогтолцоог бий болгоно.
- 6.3 Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хөрсний чанарыг сайжруулах зорилгоор гэр хорооллын айл өрх бүрт хашаандaa мод тарих, хүлэмжийн аж ахуй дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгоно.
- 6.4 Гэр хорооллыг инженерийн дэд бүтэц (цэвэр ус, бохир ус ариутгах татуурга, интернэтийн шилэн кабель)-д холбох, дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлэн, амьдран суух байшингаа барих, өөрчлөхийг урт хугацаатай, хүү багатай, орон сууцны ипотекийн зээлтэй уялдуулан хэрэгжүүлнэ.
- 6.5 Гэр хорооллыг галлагаагүй бус болгох үүднээс халаалтын шинэ технологийг дэмжиж, түлшний хэрэглээг аюулгүй болгох, агаар дахь хорт хийн хэмжээг эрүүл ахуйн шаардлага стандартын хэмжээнд хүргэнэ.
- 6.6 Байшин, амины орон сууцны дулаан алдагдлыг бууруулахад иргэдийн оролцоог дэмжих, төсөл хэрэгжүүлнэ.
- 6.7 Гэр хорооллын айл өрхийг чанартай цахилгаан эрчим хүчээр хангах үүднээс дэд станцуудыг өргөтгөнө.
- 6.8 Нүхэн жорлонг шат дараагаар хална. Өрхийн хэрэгцээний цэвэрлэх байгуулах нөхцлийг бүрдүүлнэ.
- 6.9 Үерийн далан сувгуудыг шаардлагатай газруудад нэмж барих, сайжруулах ажлыг жил бүр үе шаттай хийнэ.
- 6.10 Гудамж талбайн камержуулт, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэн гэмт хэргийн гаралтыг бууруулж, хяналтыг сайжруулна.
- 6.11 Гэр хорооллын гудамж хоорондын авто замыг сайжруулна.

ДОЛОО. ӨРХИЙН АМЬЖИРГАА, ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

- 7.1 Хувийн хэвшлийн хийх боломжтой ажлыг төр хийдэггүй байх зарчмыг баримтлана.
- 7.2 Уурхай дагасан хөгжлөөс чөлөөт эдийн засагтай, үйлдвэрлэл хөгжсөн хот болох таатай орчныг бүрдүүлнэ.
- 7.3 Эрдэнэт хотод үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн үйлчилгээг гаднаас худалдан авалт хийхгүй, зорилтот жижиг, дунд үйлдвэрийг байгуулах, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг бойжуулахыг бодлогоор дэмжинэ.
- 7.4 Байшин, амины орон сууцны дулааны алдагдлыг бууруулах чиглэлийн барилгын материал үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.
- 7.5 Үйл ажиллагаа явуулдаг төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компанийд бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа орон нутгийн аж ахуйн нэгжүүдэд давуу эрх олгох тогтолцоог өргөжүүлнэ.
- 7.6 Жаргалант сумыг түшиглэн “Экологийн цэвэр хүнс” хөтөлбөр хэрэгжүүлж, үнэлэмжийг өсгөнө.
- 7.7 Өвлийн хүлэмж, зоорь барихыг дэмжинэ.
- 7.8 Инновацийн сууриссан гарааны бизнесийг дэмжинэ.

- 7.9 Гахай, шувуу, зөгий, загас үржүүлгийн аж ахуй эрхлэх, хөгжүүлэх санаачилгыг дэмжинэ.
- 7.10 Уул уурхай, хөдөө аж ахуй, зам, барилгын тоног төхөөрөмж ба бусад төрлийн металл/зэс/, резинэн хийцийн эд ангийн үйлдвэрлэл, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн үйлдвэрлэлийг дэмжсэн цогц төлөвлөгөө хэрэгжүүлнэ.
- 7.11 Орон нутгийн хөрс, цаг уурын онцлогт тохирсон ургамлын аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлж, импортыг орлох органик брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх санал санаачилгыг бүх талаар дэмжинэ.
- 7.12 Эрдэс болон органик гаралтай бордооны дотоодын үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлж, хангамжийг нэмэгдүүлнэ.
- 7.13 Органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд сертификат олгож, хоол хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэлтийн сүлжээг боловсронгуй болгоно.
- 7.14 Өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэлийн зориулалттай зээлийн сан, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар шинэ ажлын байр бий болгоно.
- 7.15 Ажиллах хүчийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, ажлын байр олноор бий болгохыг нэн тэргүүний зорилт гэж үзэн шинэ ажлын байрыг бий болгох бүтээн байгуулалт, бизнесийн төслүүдийг бүх талаар дэмжих хөгжүүлнэ.